



**Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 1 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэн 14 заалт бүхий 4 тогтоол гаргалаа.

**Шилдэг сумдын хурлыг шалгарууллаа.**

1-р сарын 22-23 нд сумдын ИТХ-ын дарга нарын цугларалтаар 2014 оны сумдын ИТХ-ын ажлыг дүгнэж тэргүүний хурал, нарын бичгийн дарга, иргэний танхим, багийн ИНХ-ыг шалгарууллаа.

**Тэргүүний сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар**

- 1-р байр Ичинхорлоо даргатай Өндөрхангай сумын хурал
- 2-р байр Жавхлантагсар даргатай Улаангом сумын хурал
- 3-р байр Чимэд даргатай Баруунтуруун сумын хурал

**Шилдэг нарын бичгийн даргаар**

- 1-р байр Өндөрхангай сумын хурлын нарийн бичгийн дарга А.Даваажаргал
- 2-р байр Цагаанхайрхан сумын хурлын нарийн бичгийн дарга Я.Самбуу
- 3-р байр Наранбулаг сумын хурлын нарийн бичгийн дарга Орсоо



**Шилдэг иргэний танхимаар**

- 1-р байр Зүүнхангай сумын иргэний танхим Одгэрэл
- 2-р байр Хяргас сумын иргэний танхим Бааст
- 3-р байр Улаангом сумын иргэний танхим Отгон

**Шилдэг багийн иргэдийн нийтийн хурлаар**

Ховд сум Халиунбулаг багийн Иргэдийн нийтийн хурал тус тус шалгарлаа.

**Аймгийн ИТХ-ын ажлын төлөвлөгөө батлагдлаа**

Аймгийн ИТХ-аас 2015 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нийт 5 бүлэг 112 зүйлтэйгээр боловсруулан 2 үе шаттайгаар хэлэлцүүлэн Тэргүүлэгчдийн хурлаар батлууллаа. Энэ жилийн ажлын төлөвлөгөөнд иргэдэд хүрч ажиллах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Ногоон байгууламж Ногоон хөгжил, Сэтгэдэг сургууль Бүтээдэг аймаг, Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье, Авто зогсоол соёлтой үйлчилгээ, Бидний хот бидний гэр, Соёлтой үйлчилгээ, хотын тохижилт аяныг өрнүүлэн ажиллахаар боллоо.

**Увс аймагт Шилэн данс хууль бүрэн нэвтэрлээ**

Шилэн дансны хууль Увс аймагт амжилттай хэрэгжиж байна. Увс аймгийн хувьд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах “Шилэн халаас” хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан нь Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхэд сайнаар нөлөөллөө. Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор 2012 оноос Увс аймагт шилэн халаас хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд байгууллагууд төсвийн зарцуулалт, худалдан авалтаа сар, улирал жилээр байгууллагынхаа цахим хуудас болон мэдээллийн самбараар олон нийтэд хүргэж хэвисэн.



Шилэн дансны хуулийн дагуу байгуу төсөвт байгууллагууд, төрийн болон орон өмчийг үйлдвэр, аж ахуйн нэгжүүд тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байрлуулах ёстой. Увс аймгийн хувьд 221 байгууллага мэдээллээ Шилэн дансны цахим хуудсанд байшуулж дуусчээ.

**“Сэтгэдэг сургууль-Бүтээдэг аймаг”**

**бодлогыг хэрэгжүүлнэ**

2015 оны 01-р сарын 23-ны 14-цагт Увс аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, НХХ-ийн дарга Б.Ядамсүрэн нар Улаангом



политехник коллеж болон ерөнхий боловсролын сургуулийн технологийн нийт 40 гаруй багштай уулзалт хийлээ. Уулзалт ярилцлагын гол сэдэв нь аймгийнхаа 90 жилийн ойттой уялдуулан бүтээлч санаачилгыг өрнүүлж, ажил хэрэг болгох явдал. Г у д а м ж т а л б а й и н тохижилт, хөшөө дурсгал, бэлэг, сувинер, лого бэлэг тэмдэг гээд уран бүтээлч сэтгэлгээтэй хүмүүсийн санаачилга, оролцоо чухал хэрэгтэй байгаа бөгөөд улмаар сурагчдын шилдэг бүтээлийг аймгийн 90 жилийн ойн бэлгийн дээжид оруулах, сурагчдын бүтээлээр дагасан дэлгүүр ажиллуулах зэргээр хүүхдээсээ эхлээд, багш эцэг эх, хувийн хэвшлийнхний ашиг орлогыг нэмэгдүүлэх ажлыг үр ашигтай зохион байгуулах нь ойн хүрээнд иргэддээ оруулж буй хөрөнгө оруулалт болох юм.

**Хууль сахиулах байгууллагын нэгдсэн зөвлөгөөн зохион байгууллаа**


Увс аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулах салбар зөвлөлөөс шүүх, прокурор болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг энэ сарын 29-нд зохион байгууллаа. Тус зөвлөлөөс 2014 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд жигд явуулах, ирээд, олон нийтэд зориулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдээллээр хангах, гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хурдан шуурхай хүлээн авч холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэн ажиллахыг зорьжээ. Энэ хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулсан байна.



Түүнчлэн байгууллага, аж а х у й н н э г ж и й г камержуулах асуудлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлэж 155 байгууллага, аж ахуйн нэгж камертай болсон нь гэмт хэрэг гарах нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх, аливаа хэрэг, зөрчлийг хурдан шуурхай илрүүлэхэд үр нөлөөтэй ажил болов. Архидалтын эсрэг хамтдаа аян, архидан согуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг үе шаттайгаар үр дүнтэй зохион байгуулж, архины зохистой хэрэглээний талаарх мэдээлэл ойлголт хандлага сайжирч байна. Зөвлөгөөнөөр 2015 онд гэмт хэрэг зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар хэлэлцэх юм. Зөвлөгөөнөөс гарсан үр дүнг эргэн мэдээлнэ.

**Аймгийн ИТХ хөрөнгөө тооллоо**

Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, эдэлгээг уртасгах хяналт шалгалтыг зохион байгуулж шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг шилжүүлэх, устгах санал боловсруулж, мэргэжилтнүүдийн өмчийн картыг шинэчлээ.





ОНЦЛОХ

I CAP

### Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь сэдвээр уралдаан зарлаж дүгнэлээ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт мэдлэг ирээдэд хангалтгүй байгаа бөгөөд энэ талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гарын авлага болгон сурталчилах, шторк, кейс, зурагт хуудсаар дамжуулан үнэн зөв мэдээлэл өгөх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, дадал, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оны 12 дугаар сарын 17-ноос 2015 оны 01 дүгээр сарын 05-12-ны өдрүүдэд Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр уралдаан зарлаж дүгнэлээ.

Уралдаанд нийт 5 байгууллагаас материал ирүүлсэнээс

Увс аймгийн

Прокурорын газрын туслах прокурор Х.Энхтуул зурагт хуудас, кейсийн бүтээлээрээ 1-р байр

Увс аймгийн

Захиргааны хэргийн анхан шатны 16-р шүүхийн шүүгчийн туслах О.Батдорж кейс, шторк, зурагт хуудасны бүтээлээрээ, Увс аймгийн Цагдаагийн газрын

ОНХАХ-ын ахлах байцаагч, Цагдаагийн хошууч Ү.Баасанжав кейс, шторк, зурагт хуудасны бүтээлээрээ тус тус 2- байр

Увс аймгийн Тагнуулын газрын дэслэгч Ц.Дайчинбаяр зурагт хуудас, шторкны бүтээлээрээ тусгай байр эзэллээ.

Уг уралдаанд амжилттай оролцож байр эзэлсэн албан хаагчдад 50000-аас 200000 мянган төгрөгний шагнал гардах юм.

### Аймгийн ИТХ-ын дарга сургалт өглөө

Монгол улсын Төрийн захиргааны албан хаагчдын гүнзгийрүүлсэн сургалт" 2014.12.22-2014.12.29-ний хооронд Тайван улсад болж өндөрлөсөн бөгөөд уг сургалтанд Увс аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, ЗДТГ-ын дарга Г.Болор-эрдэнэ нар амжилттай суралцаад ирсэн билээ. Дөрвөн багц хичээл орсон эхний 2 нь болох

Е эрин үеийн манлайлын мэдлэг болон чадвар Мэдлэгт суурилсан манлайлал



Ц а х и м

засгийн хөгжил ба хэрэгжилт гэсэн сэдвүүдээр 01 сарын 12-нд аймгийн ИТХ болон ЗДТГ-ын ажилчдад, 01 сарын 19-нд аймгийн Агентлаг, газар, хэлтэсийн дарга, эрхлэгч нарт,

01 сарын 22-нд сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт тус тус өөрийн мэдсэн сурсан зүйлээ хуваалцаж мэдээлэл хийлээ. Сургалтанд нийтдээ 150 гаруй хүн хамрагдлаа.

### "Хогны менежментийг боловсронгуй болгох нь" сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлээ

"Хогны менежментийг боловсронгуй болгох нь" сэдэвт хэлэлцүүлгийг 1-р сарын 26-ны өдөр ЗДТГ-ын Иргэдийн оролцоо хуралдааны танхимд зохион байгууллаа. Энэ үеэр Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд хоггүй Улаангом болгох ажлыг гардан зохион байгуулахаар болсно мэдэгдлээ. Хамгийн гол нь цаашдаа хоггүй цэвэрхэн хот болоход төр, хувийн хэвшил, иргэдийн хувь нэмэр их гэдгийг онцолсон юм. Хот хогноосоо салах ажлыг хур хогийн цэг,

х о г и й н хөтлөөс биш хог гаргагч эх үүсвэрээс эхэлнэ. Ингэхийн тулд хогны бүтэц, хэмжээг судалж гаргаж ирэх шаардлагатай



цуглуулсан мэдээлэл судалгаандаа үндэслэн хоггүй, цэвэрхэн орчинд амьдрах дадал хэвшүүлэх ажлыг бусад оролцогч байгууллагууд хийнэ.

Хогны менежмент гэдэг нь хур хогийг цэвэрлээд дахиж хог тарих бол биш. Харин ил задгай хог хаяхгүй байх иргэн аж ахуйг нэгжсийн соёл, хогоо ангилан ялгах аж ахуйч чанар, иргэдийн ангилан ялгасан хогийг худалдан авах менежмент, дээрх харилцааг зохицуулсан эрх зүйн орчны цогц гэдгийг ойлгох нь чухал юм.

Сагил Увс аймгийн Сагил сумын ГХУСЗөвлөл 2015 оны 01-р сарын 1-ны өдөр хуралдаж дараахь асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Үүнд: 1.

Согтууруулах у н д а а худалдаалах, т ү ү г э э р ү й л ч и л д э г ц э г г ү ү д э д хяналт хийх ажлын хэсэг байгуулж,

тогтмол эргэлт шалгалт хийх хуваарь батлав. 2. "Архиггүй цагаан сар" аян зохион байгуулахаар болж уриалгыг иргэдэд хүргүүлэв.

Өлгий Төрийн дээд шагнал болох Алтангадас, Хөдөлмөрийн Хүндэт медалиар шагнагдсан Хөдөлмөр багийн өндөр настан З.Жавзан, Д.Цэвээн, Ж.Баттулга нарын шагналыг 2015- оны 01-р сарын 01-ны өдөр ИТХ-ын дарга Багийн Засаг дарга нар нь гэр гэрт нь очиж гардууллаа.

Улаанбаатар хотын Өлгий сумын оюутны зөвлөл энэ жил Аймгийн Шилдэг Оюутны зөвлөл болсонтой холбогдуулан суманд зохион байгуулагдсан сагсан бөмбөгийн тэмцээний үеэр Сумын ИТХ, ЗДТГ-аас Хүндэт Дурсамж үнэ бүхий зүйлээр шагнав.

Цагаан сарыг тохиолдуулан " Архи бус сүү өргөж золгоё" уриалгыг санаачлан гаргаж Албан байгууллага, баг, ард иргэд, аж ахуйн нэгжид уриалгыг хүргэж ажиллалаа.



### Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг  
Ө.Бадрахын гудамж,  
ЗДТГ-ын байр  
210тоот  
Утас :70453627

Утас :70452517

Утас :70452828

Факс :70452214

И Мэйл:

[uvskhural@yahoo.com](mailto:uvskhural@yahoo.com)

Вэб сайт:  
[uvs.khural.mn](http://uvs.khural.mn)

Facebook:  
[www.facebook.com/groups/uvs.ith](http://www.facebook.com/groups/uvs.ith)